



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” Ү
ОНӨААТҮГ-т сул ажлын байранд ажилтан
сонгон шалгаруулах журам батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.2, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9.5, Хөдөлмөрийн “дотоод журам”-ын 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг нэгдүгээр, “Сонгон шалгаруулалтын бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Сонгон шалгаруулалтын дүнгийн хуудас”-ыг гуравдугаар, “Сонгон шалгаруулалтын дүнгийн нэгдсэн хуудас”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдүүлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (С.Цэдэнсодном)-т үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2013 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр баталсан “Ажлын байрны сонгон шалгаруулах байнгын удирдамж”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 05 дүгээр сарын 13-ны
өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг баримтална.

1.2.Энэ журмын зорилго нь газарын зорилт чиг үүргийг мэргэжил, ур чадварын өндөр түвшинд хэрэгжүүлэх чадвартай, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан ажил горилогчийг сонгон шалгаруулж, ажил олгогчид нэр дэвшүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.

1.3.Сул ажлын байр гэж ажилтан ажлаас чөлөөлөгдсөн, өөр ажил албан тушаалд томилогдсон, эсхүл ажилтан нас барсны улмаас суларсан ажлын байр, болон бусад үндэслэлээр үүссэн сул орон тоог ойлгоно.

Хоёр.Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим

2.1.Ажил горилогчийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, нийгэм, улс төрийн үзэл бодол, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохгүй байна;

2.2.хууль дээдлэх, шударга, нээлттэй, ил тод байдлыг хангах;

2.3.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.4.сонгон шалгаруулалтад ажлын байр, албан тушаал үл хамааран хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалах

Гурав.Сул ажлын байрыг мэдээлэх, хүний нөөцийн бүрдүүлэлт

3.1.Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах зарыг газрын цахим хуудас (<http://invest.ub.gov.mn>)-д ажлын 3-5 хоног байршуулан нийтэд зарлан мэдээлсэн байна.

3.2.Газрын цахим хуудсанд байршуулах зарын мэдээлэлд тухайн ажлын байранд тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, бүртгэл хийх хугацаа, хүлээн авах хэлбэр (биечлэн болон цахим хэлбэрээр), хүлээн авах хаяг, байршил, утасны дугаар, сонгон шалгаруулалт явагдах хугацааг тодорхой заасан байна. Ажил горилогч нь Хөдөлмөрийн “дотоод журам”-ын 4 дэх хэсэгт заасан шаардлагын дагуу холбогдох материалыг бүрдүүлнэ.

3.3.Зарлагдаж буй ажлын байранд тавигдах (*тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага*)-ыг хангасан, хүсэлт гаргасан ажил горилогчийг Хүний нөөцийн мэргэжилтэн бүртгэнэ.

3.4.Ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан үндэслэлээр ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах үүргээ хэрэгжүүлэн ажилтан сонгон шалгаруулж шаардлага хангаж тэнцсэн иргэд, эзэмшсэн мэргэжил, мэргэшил, туршлагын дагуу ажилд орохыг хүсэж өргөдөл гаргасан иргэд, чиглэлийн дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн ажилтнаас хүний нөөцөд бүртгэнэ.

3.5.Хүний нөөцөд бүртгэх, бүртгэгдсэн иргэдийн бүртгэл, судалгааг Захиргааны хэлтсийн Хүний нөөцийн мэргэжилтэн хөтөлнө.

3.6.Сонгон шалгаруулалтаар авбал зохих нийт онооны 10 буюу түүнээс дээш оноо авсан иргэнийг нөөцөд авах ба нөөцөд байх хугацаа 2 жил байна.

3.7.Сул ажлын байрыг нөөцөөс нөхөх үйл ажиллагааг Захиргааны хэлтэс, Ерөнхий инженер, холбогдох хэлтсийн дарга, холбогдох хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахлах инженер, Хүний нөөцийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр (*тушаалын 2 дугаар хавсралт*) зохион байгуулж, нөөцөд бүртгэлтэй иргэдээс тухайн ажлын байранд тавигдах шаардлага боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлагыг харгалзан нөхөж болно.

3.8.Энэ журмын 3.4-т заасан мөн ажилд орох хүсэлт гаргасан ажил горилогчоос сонгон шалгаруулж Газрын даргын тушаалаар ажилд авна.

Дөрөв.Сонгон шалгаруулалтын үе шат

4.1.Сул ажлын байранд сонгон шалгаруулалтыг чадахуйн (*мерит*) зарчимд тулгуурлан ажил горилогчийн мэдлэг, боловсрол, туршлага, мэргэшил, ур чадвар, ёс зүйн хувьд нийцэж байгаа байдлыг харгалзан дараах үе шат (*төрөл*)-тай явуулна. Үүнд:

4.1.1.анкетын шалгаруулалт

4.1.2.ерөнхий мэдлэг шалгах

4.1.3.мэргэжлийн мэдлэг шалгах

4.1.4.ярилцлага хийх (*10-аас доошгүй асуулт, хариулт хэлбэрээр зохион байгуулж, сул ажлын байрыг нөхөх бүрэлдэхүүн ярилцлагын тэмдэглэл үйлдэн гарын үсгээр баталгаажуулсан байна*)

Тав.Сонгон шалгаруулалтын дүн

5.1.Сонгон шалгаруулалтын бүрэлдэхүүн нь энэ журмын 3, 4 дүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу үнэлнэ.

5.2.Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах бүрэлдэхүүний хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган гарын үсгээр баталгаажуулна.

5.3.Сонгон шалгаруулалтын дүнгийн нэгдсэн хуудас (*тушаалын 4 дүгээр хавсралт*) үндэслэн Газрын дарга эцсийн шийдвэр гаргана.

5.4.Сонгон шалгаруулалтад тэнцсэн ажил горилогчид тухайн ажлын байр буюу албан тушаалын нэр, гүйцэтгэх ажил үүрэг, үндсэн болон албан тушаалын цалингийн хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл зэрэг Хөдөлмөрийн гэрээний үндсэн болон нэмэлт нөхцөл, Хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын

тодорхойлолт, Ажилтны ёс зүйн дүрмийг Хөдөлмөрийн “дотоод журам”-ын хавсралтаар батлагдсан “танилцуулах хуудас”-ын дагуу танилцуулан гарын үсгээр баталгаажуулан Төрийн албан хаагчийн анкетад хадгална.

5.5.Ажил горилогчийг ажилд томилох тухай Газрын даргын тушаал гарч, Хөдөлмөрийн гэрээ байгуулснаар ажилтан ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээр хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүснэ.

5.6.Сонгон шалгаруулалтад оролцож сонгогдсон иргэн өөрийн хүсэлтээр тухайн ажилд томилогдохоос татгалзсан тохиолдолд дараагийн шаардлага хангасан ажил горилогчийг санал болгоно.

5.7.Газрын дарга сонгон шалгаруулалтын үр дүнг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд, сонгон шалгаруулах бүрэлдэхүүн дахин нэг удаа хурал зохион байгуулж болно.

Зургаа.Бусад зүйл

6.1.Энэхүү журам нь Газрын даргын тушаалаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2.Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтныг ажил олгогчийн санаачилгаар эргүүлэн ажилд авах тохиолдолд энэ журмыг мөрдөхгүй байж болно. Харин иргэний хүсэлтээр ажилд эргүүлэн авахдаа энэхүү журмын дагуу сонгон шалгаруулалт явуулна.

6.3.Сонгон шалгаруулалтын бүрэлдэхүүн нь ашиг сонирхлын зөрчилгүй байна. Хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзвэл татгалзах үүрэгтэй.

6.4.Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэн, хариуг хүргүүлнэ.

6.5.Энэ журмыг зөрчсөн сонгон шалгаруулалтын гишүүнд Хөдөлмөрийн “дотоод журам”-ын холбогдох заалтын хүрээнд сахилгын шийтгэл ногдуулна.

6.6.Сонгон шалгаруулалтын явцын холбогдох баримт материалыг Хүний нөөцийн мэргэжилтэн дараа оны 1 дүгээр улиралд багтаан газрын архивд шилжүүлнэ.

6.7.Журамд Газрын даргын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь журмын салшгүй хэсэг болно.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны
өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

2/15



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

ГИШҮҮН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ТУХАЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТУХАЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН, АХЛАХ ИНЖЕНЕР

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны
өдрийн дугаар тушаалын гуравдугаар хавсралт



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Ажил горилогчийн мэдээлэл:

- 1.Иргэншил:
- 2.Ургийн овог:
3. Эцэг (эх)-ийн нэр:
- 4.Өөрийн нэр:
- 5.Регистрийн дугаар:
- 6.Холбоо барих утасны дугаар

Цээж зураг
4х6 см

Ажил горилогчийн сонирхож буй:

- 1.Хэлтсийн нэр:
- 2.Албан тушаал:

№	Төрөл	Авбал зохих огноо	Авсан огноо
1	Ерөнхий мэдлэг (боловсрол, туршлагын байдал)	5	
2	Мэргэжлийн мэдлэг (мэргэшсэн байдал)	5	
3	Ярилцлагын оноо	5	
Нийт дүн		15	

Дарга: Захиргааны хэлтсийн дарга: (гарын үсгийн тайлал)
(гарын үсэг)

Гишүүд: Ерөнхий инженер: (гарын үсгийн тайлал)
(гарын үсэг)


Холбогдох хэлтсийн дарга: (гарын үсгийн тайлал)
(гарын үсэг)

Холбогдох хэлтсийн ахлах мэргэжилтэн,
ахлах инженер: (гарын үсгийн тайлал)
(гарын үсэг)

Нарийн бичгийн

дарга: Хүний нөөцийн мэргэжилтэн: (гарын үсгийн тайлал)
(гарын үсэг)

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 03 дүгээр сарын 13-ны
өдрийн дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН НЭГДСЭН ХУУДАС

Сонгон шалгаруулалт зарласан ажлын байр:

1.Хэлтсийн нэр:

2.Албан тушаал:

3.Мэргэжил:

№	Төрөл	Авбал зохих оноо	Эцэг (эх)-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар:	Эцэг (эх)-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар:	Эцэг (эх)-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар:
1	Ерөнхий мэдлэг (боловсрол, туршлагын байдал)	5			
2	Мэргэжлийн мэдлэг (мэргэшсэн байдал)	5			
3	Ярилцлага	5			
Нийт дүн		15			

Дарга: Захиргааны хэлтсийн дарга: (гарын үсгийн тайлал)
(гарын үсэг)

Нарийн бичгийн
дарга: Хүний нөөцийн мэргэжилтэн: (гарын үсгийн тайлал)
(гарын үсэг)

20... он ... сар ... өдөр